

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 09 сарын 15 өдөр

Дугаар А/23

Арвайхээр

Улирлын томуугийн эсрэг вакцинаар
дархлаажуулах тухай

Эрүүл мэндийн сайдын 2021 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн “Улирлын томуугийн эсрэг вакцинаар дархлаажуулах тухай” А/565 дугаар тушаалыг үндэслэн ТУШААХ нь:

1. Дархлаажуулалтын ээлжит 10 хоногийг 2021 оны 9 дүгээр сарын 13-наас 22-ны өдрүүдэд “Томуугаас сэргийлье” уриан дор зохион байгуулсугай.

2. Дархлаажуулалтын 10 хоногоор эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрлийг үндэслэн 2-11 насны хүүхэд, жирэмсэн эмэгтэйг Бүгд Найрамдах Солонгос Улсын Грийн кросс үйлдвэрийн улирлын томуугийн “GCFLU” гурван цэнт вакцинаар дархлаажуулах ажлыг зохион байгуулахыг Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Заавал хийх товллын дархлаажуулалтаас хоцорсон 0-15 насны хүүхдийг нөхөн дархлаажуулахыг Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт даалгасугай.

4. Улирлын томуугийн “GCFLU” гурван цэнт вакцин, дагалдах хэрэгслийн хуваарийг хавсралтаар баталсугай.

5. Улирлын томуугийн эсрэг вакцинжуулалтыг коронавируст халдвар (ковид-19)-ын эсрэг вакцинжуулалтын цэгээс тусад нь зохион байгуулж, томуу, томуу төст өвчнөөс сэргийлэх, дархлаажуулалтын ач холбогдлыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлахыг Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс (М.Золзаяа), Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт тус тус даалгасугай.


6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ мэдээллийн хэлтэс (Я.Жаргал)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ШИВААННҮРДЭВ

Эрүүл мэндийн газрын даргын 2021
оны 09 сарын 11-ны өдрийн 4/23 дугаар
тушаалын хавсралт



УЛИРЛЫН ТОМУУГИЙН "GSFLU" ГУРВАН ЦЭНТ ВАКЦИН,
ДАГАЛДАХ ХЭРЭГСЛИЙН ХУВААРЬ

№	Сумын нэр	Зорилтот бүлэг		Нийт	Шаардагдах дагалдах хэрэгсэл	
		Жирэмсэн	2-11 насны хүүхэд		Вакцин хүн тун	Тариур 1 мл
1	Баруунбаян-Улаан	10	300	310	310	310
2	Бат-Өлзий	50	600	650	650	650
3	Баянгол	20	300	320	320	320
4	Баян-Өндөр	20	300	320	320	320
5	Богд	40	600	640	640	640
6	Бүрд	20	300	320	320	320
7	Гучин-Ус	10	200	210	210	210
8	Есөн-зүйл	20	200	220	220	220
9	Зүүнбаян-Улаан	20	400	420	420	420
10	Нарийнтээл	30	300	330	330	330
11	Өлзийт	20	200	220	220	220
12	Сант	20	300	320	320	320
13	Тарагт	20	300	320	320	320
14	Төгрөг	10	200	210	210	210
15	Уянга	60	1000	1060	1060	1060
16	Хайрхандулаан	20	300	320	320	320
17	Хархорин	30	1200	1230	1230	1230
18	Хужирт	50	700	750	750	750
19	нарны дөш	130	1520	1650	1650	1650
20	Уян сэтгэл	90	1100	1190	1190	1190
21	Түшигдөлгөөн	80	1100	1180	1180	1180
22	Нийт	770	1420	12190	12190	12190